



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 06 өдөр

Дугаар А/493

Бсөнбулаг

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай" 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны "Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай" 211 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 108 дугаар гэрээт Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:	Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн ерөнхий архитектор)
Гишүүдэд:	М.Мандахүү	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
	Ж.Мөнхчимэг	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн газрын харилцаа, барилга хот байгуулалт, нийтийн аж ахуй, хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн)
	Д.Отгонжаргал	(аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
	Н.Долгорсүрэн	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн хяналтын хэлтсийн ахлах инженер)
	Э.Пүрэвжаргал	("Барилгын хөгжлийн төв" ТӨҮГ-ын барилга байгууламжийн захиалагчийн инженер)
	П.Аззаяа	(Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, ахлах дэслэгч)

0201000744

2.

- Б.Батбилэг (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
- Г.Золзаяа (Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч)
- Г.Билэгсайхан (Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн)
- Г.Лхагвасүрэн (Цогт сумын Баянтоорой тосгоны захирагч) (ашиглагч)
- Р.Даваахорол (Цогт сумын Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн эрхлэгч) (ашиглагч)
- Б.Бээжин ("Алтай-Улиастайн эрчим хүчний систем" ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)
- Д.Цэвэлмаа ("Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-ийн ерөнхий инженер)
- Ч.Нарандэлгэр ("Барилга байгууламж" ХХК-ийн захирал) (зохиогч)
- Ш.Болдбаатар ("Мөрөн-Алтай" ХХК-ийн захирал) (гүйцэтгэгч)

Нарийн бичгийн дарга:Б.Цэрэндаваа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын хяналтын инженер)

2.Барилга байгууламжийн угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2023 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулахыг комисс (Б.Бямбадорж)-т үүрэг болгосугай.

3.Холбогдох акт, баримт бичгийг үндэслэн орон нутгийн өмчид бүртгэхийг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), барилга байгууламжийн урсгал зардлыг төсөвт тусгаж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Цогт сумын Баянтоорой тосгоны захирагч (Г.Лхагвасүрэн), Баянтоорой тосгоны Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Р.Даваахорол)-д тус тус даалгасугай.

ОРЛОГЧ  Г.ЧИНБАТ

